

2 БУРХАН ТАНЫГ ДАРУУСГАЖ БАЙНА УУ?

2.1 ТАНЫ НЭР БИЧИГДСЭН ҮҮ?

ЭЗЭН Бурхан чинь чамайг энэ дөчин жилийн түрш цөлд удирдсан бүх л зам мөрийг дурсан сана. Энэ нь чиний зүрхэнд юу байсныг, Түүний тушаалыг дагах эсэхийг чинь мэдэхийн тулд, чамайг номхтгож, шалгаж сорихын тулд байсан юм. 3 Хүн зөвхөн талхаар амьдардаггүй, харин хүн ЭЗЭНий амнаас гарах үг бүхнээр амьдардаг гэдгийг чамд ойлгуулахын тулд Тэрээр чамайг номхтгон, чамайг өлсгөж, чиний мэддэггүй, чиний өвөг дээдэс ч мэддэггүй байсан “манна”-гаар чамайг хооллож (Дэд хууль 8:2 – 3)

Миний зовон шаналсан нь, Таны зарлигуудыг сурах болсон нь надад тустай. (Дуулал 119:71)

[] Хэлсэн үг нь Түүний хүүхдүүдийн амьдралд сүнсний хоол, заавар болдог гэдэгт та итгэдэг үү?

[] Та цөл дэхь дуулгавартай байдлын сургалтыг давж чадсан уу?

2.2 МИНИЙ СУУРИЙН ХЯНАЛТЫН ШАЛГУУРУУД

[] Миний суурь бол бат бөх хад болох Бурханы үг юм.

Бурхан сайн, муу гэж ялгалгүй нууцлагдсан юмс бүрийг, бүх үйлсийг шүүлтэд аваачих болно. (Номлогчийн үгс 12:14),

Тиймд эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу үйлдэгч аливаа хүн хадан дээр байшингаа барьсан мэргэн хүнтэй зүйрлэгдэнэ. 25 Бороо орж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэн боловч тэр нь нурсангүй. Учир нь байшин хадан дээр суурилагдсан байв. 26 Эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу үл үйлддэг аливаа хүн элсэн дээр байшингаа барьсан мунхаг хүнтэй зүйрлэгдэнэ. 27 Бороо орж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэнд байшин нурав. Эвдрэл нь асар их байлаа гэв. (Матай 7:24 – 27)

[] Надад байгаа бүхэн Бурханд хамаатай гэдгийг би мэднэ.

Дэлхий болон түүнийг дүүргэдэг бүхэн, Ертөнц хийгээд түүнд оршигчид ЭЗЭНийх юм. (Дуулал 24:1)

[] Бурхан бэлтгэгдсэн зүрх, цэвэр савыг ашигладаг гэдгийг би мэднэ.

Том байшинд зөвхөн алт, мөнгөн сав суулга байдаггүй. Мөн модон, шавран сав суулга ч байдаг. Зарим нь хүндэтгэлд, зарим нь жирийн үед хэрэглэгддэг. (2 Тимот 2:20)

[] Эрдэм чадал чадвараар бус Түүний нигүүлслийн улмаас би ерөөлийг гуйдаг юм.

Бурхан биднийг нигүүлсэн, биднийг ерөөж, Өөрийн нүүрийг бидний дээр тусгаач. Села 2 Энэ нь Таны зам дэлхий дээр, Таны аврал бүх үндэстнүүдийн дунд танигдахын тулд билээ. (Дуулал 67:1 – 2)

[] Амьдрал ерөөл, шүүлт гэсэн хоёр л замтай гэдгийг би мэднэ.

Хорон муу хүний зөвлөгөөг дагадаггүй, Нүгэлтнүүдийн зам дээр ч зогсдоггүй, Басамжлагчдын суудалд ч суудаггүй хүн ерөөлтэй еэ! 2 Харин тэрээр ЭЗЭНий хуульд баярлаж, Түүний хуулийг өдөр шөнөгүй тунгаан бясалгадаг. 3 Тэрээр урсгал усны дэргэд тарьсан мод адил билээ. Тэр мод цагтаа үр жимсээ ургуулдаг бөгөөд Навчис нь ч хатдаггүй. Тэр хүний үйлс бүхэн нь өлзийтэй. (Дуулал 1:1 – 3)

2.3 ТА ТҮҮНИЙ ХАЙРЫГ ОЙЛГОДОГ УУ?

Өнөөдөр миний чамд тушааж буй Түүний тушаал, хууль, зарлигийг сахилгүй, өөрийн Бурхан ЭЗЭНийг мартахаас болгоомжлоорой. 12 Чи идэж цадаад, сайхан байшин барьж, тэндээ амьдран, 13 мал сүрэг чинь үржин олширч, алт мөнгө чинь арвижиж, чамд байгаа бүхэн чинь өсөн нэмэгдэх үед 14 чиний зүрх бардам болж, өөрийн Бурхан ЭЗЭНийг мартуузай. Тэр Египетийн нутгаас, боолчлолын гэрээс чамайг гаргаж аваад, 15 өргөн уудам, аймшигт цөл дундуур, галт могой, хилэнцэт хорхойтой, усгүй ангамал газраар удирдан дагуулж, чиний төлөө цахиур чулуунаас ус гаргаж өгсөн билээ. 16 Чамайг номхтгон, чамайг сорьж шалгаад, эцэст нь чамайг сайн сайхан амьдруулахын тулд Тэрээр чиний өвөг дээдэс ч мэддэггүй байсан “манна”-гаар цөлд чамайг хооллож байсан билээ. 17 “Би хүч тэнхээ, гарынхаа чадлаар энэ хөрөнгө чинээг өөртөө бий болгосон юм” гэж чи зүрхэндээ хэлүүзэй. 18 Харин өвөг дээдэст чинь тангарагласан Өөрийнхөө гэрээг өнөөдрийнх шиг батлахын

тулд Тэр чамд хөрөнгө чинээ олох хүч чадлыг өгдөг учраас чи өөрийн Бурхан ЭЗЭНийг санагтун. 19 Хэрэв чи өөрийн Бурхан ЭЗЭНийг мартаж, өөр бурхдыг дагаж, тэдэнд үйлчлэн, тэдэнд мөргөвөөс чи гарцаагүй устах болно хэмээн би өнөөдөр та нарын эсрэг гэрчилж байна. (Дэд хууль 8:11 – 19)

ЭЗЭН гэрийг барьж байгуулахаас нааш Түүнийг байгуулагчид дэмий хөдөлмөрлөдөг юм. ЭЗЭН хотыг хамгаалахаас нааш Манаач хүн дэмий л сэрүүн байдаг юм. 2 Та нарын хувьд эрт босон, Орой болтол унтахгүй байж, Зүтгэж олсон талхыг идэх нь дэмий хоосон юм. Учир нь Тэр Өөрийн хайрладаг хүндээ нойрыг өгдөг билээ. (Дуулал 127:1 – 2)

[] Та аливаа нэгэн ерөөлийг хараал болгож чадна гэдгээ мэдэж байсан уу?

[] Та байгаа бүх зүйлийнхээ төлөө болон амьдралын бэрхшээлээс чөлөөлснийх нь төлөө Түүнд талархдаг уу?

[] Даруу байдал нь хүүхдүүддээ хайртай Бурханы бэлэг гэдэгт та итгэдэг үү?
[] Ихэмсэг зүрх бол Бурханы шүүлт ойрхон байгаагийн дохио гэдгийг та мэдэх үү?

2.4 ТАНД ЭДГЭЭР НЬ БИЙ ЮУ?

2 Бурхан болон бидний Эзэн Есүсийг мэдсэнээр та нарт нигүүлсэл ба амар амгалан улам арвин болохыг ерөөе. 3 Өөрийнхөө алдар ба давуу чанараар биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжуулан Түүний бурханлаг хүч бидэнд амь болоод сүсэглэлд хамаатай бүхнийг соёрхсон. 4 Эдгээрээр дамжуулан Тэр бидэнд үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтуудаа соёрхсон. Ингэснээр та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурханлаг мөн чанарын хуваалцагч болох юм. (2 Петр 1:2 – 4)

[] Зүрх сэтгэлдээ амар амгалан байх нь тухайн хүний Бурхантай харилцах харилцааны байдлыг илтгэдэг гэдэгт та итгэдэг үү?

14 Тиймээс хайртууд минь, та нар эдгээрийг хүлээж буй учраас амар амгалан дотор болон толбогүй бөгөөд гэм зэмгүйгээр Түүнд олдохыг хичээгтүн. 15 Бидний хайрт ах Паул өөрт нь өгөгдсөн мэргэн ухааны дагуу та нарт бичсэнчлэн бидний Эзэний гэвчээрийг аврал хэмээн тооц. 16 Тэрчлэн түүний бүх захидалд эдгээрийн талаар бичсэн юм. Захидлуудад нь ойлгоход хэцүү зарим зүйл байдаг бөгөөд харанхуй мунхаг, гуйлбаргүй хүмүүс Судрын бусад зүйлсийг ч гуйвуулдаг шигээ тэдгээрийг мушгин гуйвуулж өөрсдийгөө сүйрүүлдэг. 17 Тиймээс хайртууд минь, та нар үүнийг урьдаас мэдэж, өөрсдийгөө сэргийл. Эс тэгвэл та нар ёс зарчимгүй хүмүүсийн төөрөгдөлд автаж, тогтвортой байдлаа алдчих вий. 18 Харин бидний Эзэн бөгөөд Аврагч Есүс Христийн нигүүлсэл болон мэдлэг дотор өсөгтүн. Эдүгээ болон мөнхийн өдөрт аль алинд нь Түүнд алдар байх болтугай. Амен. (2 Петр 3:14 - 18)

[] Та баяр хөөртэй сэтгэл зүрхээр Бурхангай нүүр тулж чадах уу?

2.5 ХЭН ХУДАЛ ХЭЛЖ БАЙГААГ ТЭ МЭДЭХ ҮҮ?

18 Нялхас аа, энэ бол эцсийн цаг. Христийг эсэргүүцэгч нь ирж байна гэж та нар сонссончлон, одоо ч гэсэн Христийг эсэргүүцэгчид олноороо гарч ирж байна. Энэ нь эцсийн цаг гэдгийг бид үүнээс мэднэ. 19 Тэд бидний дундаас гарсан боловч биднийх биш. Учир нь хэрэв тэд биднийх байсан бол, тэд бидэнтэй хамт байх байсан. Харин тэд гарсан нь тэднийг бүгд биднийх биш гэдгийг үзүүлэхийн тулд юм. 20 Харин та нар Ариун Нэгэнээр тослогдсон бөгөөд бүхнийг мэднэ. 21 Та нар үнэнийг мэдэхгүй тул би бичсэн биш, харин түүнийг мэддэг бөгөөд ямар ч худал нь үнэнээс гардаггүй учир би та нарт бичсэн. 22 Есүс бол Христ гэдгийг үгүйсгэдэг нэгнээс өөр хэн худалч юм бэ? Энэ бол Христийг эсэргүүцэгч буюу Эцэг болоод Хүүг үгүйсгэгч юм. 23 Хэн Хүүг үгүйсгэнэ түүнд Эцэг байхгүй. Хүүг хэн хүлээн зөвшөөрнө түүнд Эцэг ч бий. 24 Эхнээсээ сонссон зүйл чинь та нарын дотор байг. Хэрэв эхнээсээ сонссон зүйл чинь та нарын дотор байвал, та нар мөн Хүү болоод Эцэгийн дотор байх болно. 25 Энэ бол Тэр Өөрөө бидэнд амласан амлалт болох мөнх амь юм. 26 Та нарыг мэхлэхийг оролдож буй хүмүүсийн талаар эдгээрийг би та нарт бичсэн. 27 Та нарын Түүнээс авсан тосолгоо нь та нарын дотор байдаг бөгөөд өөрсдөд чинь заах хэн нэгэн та

нарт хэрэггүй. Харин Түүний тосолгоо нь та нарт бүхнийг заадаг бөгөөд тэрхүү тосолгоо нь худал биш, үнэн. Та нарт заасан ёсоор та нар Түүний дотор байгтун.
(1 Иохан 2:18 – 27)

[] Есүс Христ бол Бурхан Эцэгээс гаралтай гэдгийг үгүйсгэдэг хэн боловч антихрист гэдгийг та мэдэх үү?

[] Та Христ Есүсийг өөрийн аврагчаар хүлээн авах үед амласан тосолгоо болох Ариун Сүнс таны дотор оршдог гэдэгт та итгэдэг үү?

[] Эцсийн цаг үеийн шинж тэмдэг нь буруу сургаал, үйлдлүүдийг зөвтгөх явдал гэдгийг та мэдэх үү?

2.6 ТАНЬД ТЭРХҮҮ ТОСОЛГОО БАЙГАА ЮУ?

27 Та нарын Түүнээс авсан тосолгоо нь та нарын дотор байдаг бөгөөд өөрсдөд чинь заах хэн нэгэн та нарт хэрэггүй. Харин Түүний тосолгоо нь та нарт бүхнийг заадаг бөгөөд тэрхүү тосолгоо нь худал биш, үнэн. Та нарт заасан ёсоор та нар Түүний дотор байгтун. 28 Бяцхан хүүхдүүд ээ, одоо та нар Түүний дотор бай. Тэгвэл Түүнийг үзэгдэх үед бид Түүний өмнө зоригтой байж, Түүнийг ирэхэд өмнө нь ичгүүргүй байх болно. 29 Хэрэв та нар Түүний зөвт гэдгийг мэдвэл, зөвийг үйлдэгч хүн бүр Түүнээс төрсөн гэдгийг бас мэднэ. (1 Иохан 2:27 - 29)

1 Бид Бурханы хүүхдүүд гэж дуудуулахаар ямар их хайрыг Эцэг бидэнд соёрхсоныг хараач! Бид бол тийм юм. Иймээс ертөнц Түүнийг мэдээгүй тул биднийг мэддэггүй. 2 Хайртууд минь, бид одоо Бурханы хүүхдүүд. Бидний ямар байх нь хараахан үзэгдээгүй. Түүнийг үзэгдэх үед бид Түүнтэй адил болно гэдгийг мэднэ. Учир нь бид Түүнийг яг байгаагаар нь харах болно. 3 Түүнд ийнхүү найдаж байгаа аливаа хүн өөрийгөө цэвэршүүлдэг. Учир нь Тэр цэвэр ажээ. 4 Нүгэл үйлддэг хүн бүр бас ёс бус хэрэг үйлддэг. Нүгэл бол ёс бус хэрэг юм. 5 Нүглүүдийг зайлуулахын тулд Тэр үзэгдсэн гэдгийг та нар мэднэ. Түүнд ямар ч нүгэл байхгүй. 6 Түүний

дотор байгч хэн ч нүгэл үйлддэггүй. Нүгэл үйлддэг хэн ч Түүнийг үзээгүй, мэдээгүй. (1 Иохан 3:1 – 6)

[] Таныг Сүнс Бурханы Үгэнд удирдахад та амьдралдаа зөвт байдлыг хэрэгжүүлдэг үү?

[] Тослогдсон хүн Бурханы зарлигуудыг сахидаг гэдгийг та мэдэх үү?

БУРХАНТАЙ НЭГДЭХГҮЙ БОЛ ЗАЛБИРАЛ ХАРИУЛТ ҮГҮЙ

2.7 ТАНЫ ХАЙРТАЙ ХҮМҮҮСИЙН НЭР БИЧИГДСЭН ҮҮ?

Хүний хүү чи тэрслүү гэрийн дунд амьдарч байна. Тэд бол тэрслүү гэр учраас харах нүдтэй боловч эс харж, сонсох чихтэй боловч үл сонсдог. (Езекиел 12:2)

Сонсох чихтэй нь сонсогтун гэв. (Матай 13:9)

Гэсэн хэдий ч сүнснүүд эрхшээлд чинь орсон гэдэгт та нар бүү баярла, харин нэрс чинь тэнгэрт бичигдсэн гэдэгт баярлагтун гэв. (Лук 10:20)

33 ЭЗЭН Мосед —Миний эсрэг нүгэл үйлдсэн хэнийг боловч Би Өөрийнхөө номоос арилгана. (Египетээс гарсан нь 32:33)

Үхсэн их бага хүмүүс сэнтийн өмнө зогсож байхыг би харлаа. Номууд дэлгээстэй байв. Өөр нэгэн ном дэлгээстэй байсан бөгөөд тэр нь амийн ном юм. Үхэгсэд нь өөрсдийн үйлсийн дагуу энэхүү номд бичигдсэн зүйлсээр шүүгдэв. (Илчлэлт 20:12)

[] Хийсэн тэрслүү ажлынхаа төлөөх Бурханы шүүлтээс хэн ч зугтахгүй гэдгийг та мэдэх үү?

[] Тэнгэрт таны үйлсийн ном байгаа бөгөөд таныг хүлээж байгаа гэдгийг та мэдэх үү?

[] Таны нэр амийн номонд бичигдсэн үү?

2.8 ДЭЛХИЙ ДЭЭР БАЙХДАА ЕСҮСИЙН ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Бид энэ Дэлхийг болон үүн дээрх амьдралыг зохион бүтээгээгүй. Амьдрал бол Бүтээгч Бурханаас ирсэн бөгөөд энэ нь мөнхийн амьдрал, мөнхийн шагналыг авах боломж юм.

26 Учир нь хүн бүх дэлхийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ? Эсвэл амийнхаа оронд юугаа өгөх билээ? (Матай 16:26)

Ингэж хэлээд, Есүс тэнгэр өөд мэлмий өргөн —Аав аа, цаг нь ирлээ. Таныг Хүү чинь алдаршуулахын тулд Хүүгээ алдаршуулаач. 2 Таны Надад өгсөн бүх хүнд Хүү чинь мөнх амийг өгөхийн тулд бүх махан биеийг захирах эрхийг Та Надад өгсөн билээ. 3 Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн. 5 Одоо, Аав аа, ертөнцийг бүтээхээс өмнө Тантай хамт Надад байсан сүр жавхлангаар Та Намайг Өөрийнхөө хамт алдаршуулаач. (Иохан 17:1 – 3)

2.9 ЕСҮС ДАГАЛДАГЧДЫНХАА ТӨЛӨӨ ЗАЛБИРСАН НЬ

6 Ертөнцөөс Таны Надад өгсөн хүмүүст Би Таны нэрийг илэрхийлсэн. Тэд Таных байсан бөгөөд Та тэднийг Надад өгсөн. Тэд Таны үгийг сахисан юм. 7 Таны Надад өгсөн алив бүхэн нь Танаас ирсэн гэдгийг одоо тэд мэдэв. 8 Учир нь Таны Надад өгсөн үгсийг Би тэдэнд өгсөн. Тэдгээрийг тэд хүлээн авч, Намайг Танаас гарч ирснийг үнэхээр ойлгоод, Таны Намайг илгээсэн гэдэгт итгэсэн юм. 9 Тэдний төлөө Би гуйж байна. Би ертөнцийн төлөө бус, харин Таны Надад өгсөн хүмүүсийн төлөө гуйж байна. Учир нь тэд Таных билээ. 10 Миний бүх юм Таных, Таных бас Минийх. Тэдний дотор Би алдаршуулагдлаа. 11 Цаашид Би ертөнцөд байхгүй, харин тэд ертөнцөд байна. Би Тан уруу очно. Ариун Аав аа, Бидний адил тэднийг нэг байлгахын тулд Надад өгсөн Өөрийнхөө нэрээр Та тэднийг хамгаалаач. 12 Би тэдэнтэй хамт байхдаа тэднийг Надад өгсөн Таны нэрээр хамгаалж байсан. Би тэднийг харгалзсан бөгөөд мөхлийн хүүгээс өөр тэдний нэг нь ч мөхсөнгүй. Энэ нь Судар биелэгдэхийн тулд болсон аж. 13 Харин одоо Би Тан уруу очно. Тэдний дотор Миний баяр баясгалан дүүрэн байхын тулд энэ бүхнийг Би ертөнцөд байхдаа ярьж байна. 14 Би Таны үгийг тэдэнд өгсөн. Би ертөнцийнх биш адил тэд бас ертөнцийнх биш тул ертөнц тэднийг үзэн ядсан юм. 15 Би Танаас тэднийг

ертөнцөөс аваач гэж гуйхгүй, харин тэднийг муугаас хамгаалаач гэж гуйж байна. 16 Би ертөнцийнх биш адил тэд бас ертөнцийнх биш. 17 Үнэн дотор тэднийг ариусгаач. Таны үг бол үнэн мөн. 18 Та Намайг ертөнц уруу илгээсний адил Би тэднийг мөн ертөнц уруу илгээв. 19 Тэд бас өөрсдөө үнэн дотор ариусгагдахын тулд Би Өөрийгөө тэдний төлөө ариусгана. (Иохан 17:6 – 19)

[] Танд байгаа бүхэн Бурханаас ирсэн гэдэгт та итгэдэг үү?

[] Есүс Христ Бурханаас ирсэн бөгөөд Бүтээгч Бурхан илгээсэн гэдэгт та итгэдэг үү?

[] Есүс Христ ба Түүний нэр таныг хамгаалж чадна гэдэгт та итгэдэг үү?

[] Та Есүс Христийн нэрээр бусдыг хамгаалахын төлөө залбирдаг уу?

[] Та бусдын төлөө өөрийгөө үнэнээр ариусгадаг уу?

2.10 ЕСҮС БҮХ ИТГЭГЧДИЙН ТӨЛӨӨ ЗАЛБИРСАН НЬ

20 Би зөвхөн тэдний төлөө бус, тэдний үгээр дамжуулан Надад итгэх хүмүүсийн төлөө мөн гуйж байна. 21 Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгдээрээ нэг байхын тулд бөгөөд мөн тэд Бидний дотор байж, Таны Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ. 22 Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд Таны Надад өгсөн сүр жавхланг Би тэдэнд өгсөн билээ. 23 Би тэдний дотор, Та Миний дотор байдаг. Ингэснээр тэд төгс нэгдэн, Таны Намайг илгээснийг болон Намайг хайрласны адил тэднийг хайрласныг ертөнц мэдэх болно. 24 Аав аа, Таны Надад өгсөн хүмүүс бас Миний байх газарт Надтай хамт байж, Миний сүр жавхланг үзээсэй гэж Би хүсэж байна. Тэр сүр жавхланг Та Надад өгсөн билээ. Учир нь ертөнцийн сууриас өмнө Та Намайг хайрласан. 25 Зөвт Аав аа, ертөнц Таныг мэдээгүй боловч, Би Таныг мэдсэн. Мөн Таны Намайг илгээснийг тэд мэдсэн билээ. 26 Би Таны нэрийг тэдэнд мэдүүлсэн бөгөөд мэдүүлэх болно. Ингэснээр Таны Намайг хайрласан тэр хайр тэдний дотор байж, Би ч гэсэн тэдний дотор байх юм гэлээ. (Иохан 17:20 - 26)

8 Бүх ариун хүмүүсээс хамгийн өчүүхэн нь болох надад энэхүү нигүүлсэл өгөгдсөний учир нь Христийн нэвтэршгүй баялгийг харь үндэстэнд тунхаглаж, 9 бүх юмсыг бүтээсэн Бурханы дотор үеэс үед нууцлагдаж байсан нууцын үйлчлэлийн үүрэг нь юу болохыг [бүгдэд] мэдүүлэхийн тулд байлаа. 10 Ингэснээр эдүгээ чуулганаар дамжуулан Бурханы олон янзын мэргэн ухаан тэнгэрлэг газар дахь захирагчид болон эрх мэдэлтнүүдэд мэдэгдэх юм. 11 Бидний Эзэн Христ Есүсийн дотор үйлдсэн мөнхийн зорилгын дагуу Тэр ингэсэн ажээ. 12 Бид Христэд итгэх итгэлээрээ дамжуулж Түүнд зоримог байдал ба бат итгэлтэйгээр очиж болно.
(Ефес 3:8 - 12)

[] Есүсийн залбиралдаа та бид хоёрыг багтаасан гэдэгт та итгэдэг үү?

[] Залбирлын зорилго нь Түүнтэй хамт байх явдал гэдэгт та итгэдэг үү?

[] Бурхан цорын ганц Хүү Есүс Христээ илгээсэн гэж та тунхаглаж байна уу?

[] Таны залбиралаар дамжуулан түүний дуулгавартай дагалдагч нар Есүсийн нэрээр хамгаалалтыг хүсдэг. Та тэдний хамгаалалтын төлөө залбирдаг уу?

[] Израильчуудтай хийсэн энэ бүх гэрээ, адислал ерөөл нь хэрхэн таньтай хамаатай болохыг та мэдэх үү?

2.11 МИНИЙ АЖЛЫН ЭЦСИЙН ТАЙЛАН

Хэрэв энэ нь тэнгэрийн хаанчлалын төлөө ажлын сүүлийн долоо хоног гэвэл танд мөнхийн амь өгөх Түүнд тайлангаа хэрхэн бичих вэ?

[] Энэ амьдралдаа юу хийснээ тайлагна.

Эдгээрийг анхаарч үзээрэй.

Дуудлага юу байсан бэ?

Та яаж (дуулгавартай дагасан) хийсэн бэ?

Үр дүн (жимс) юу вэ?

Хэрэв та дагалдагчтай байсан бол түүнд ямар хүсэлт тавих вэ?

Түүний хаанчлал ирэхтэй холбоотой өөр ямар нэгэн хүсэлт байна уу?

2.12 БИ ӨӨРИЙГӨӨ ХАРЖ БАЙНА УУ?

Хэрэв та өөрийгөө харж чадахгүй бол
 Бурханыг харж чадахгүй.
 Хэрэв та өөрийгөө харж чадвал,
 Бурханыг харж чадна.
 Хэрэв та Түүний үгийн дагуу гэмших юм бол
 Та Түүний үгийг мэдрэх болно.
 Хэрэв та Түүний үгийг дагавал
 Та түүнтэй хэрхэн алхахыг мэддэг .

Хичээлээр дамжуулан бид залбирч, мэддэг зүйлээ хэрхэн дагаж мөрдөх, амьд Бурхантай хэрхэн нэгдэж чадах талаар сурч авна.

Үргэлж баяртай байж
 Тасралтгүй залбир
 Бүх зүйлд талархаж байгаарай
 Сүнсийг бүү бөхөө
 Эш үзүүллэгийг үл тоомсорлож болохгүй
 Бүх зүйлийг шалгаж үзээд сайныг нь барьж ав
 Муугийн бүх хэлбэрээс зайлсхий
 Есүс Христ дотор Түүнтэй НЭГ бол

2.13 БУРХАНЫ ҮГИЙГ ӨДӨР БҮР БЯСАЛГА

Нэг бүлгийг гүн гүнзгий төвлөрч уншаарай. Бурханы үгийг уншиж сонсож байхдаа зүрх сэтгэлдээ сонсож буй зүйлийг тэмдэглэлийнхээ дэвтэрт бичээрэй.

Судрыг унших, идэх хоёрын ялгаа (бясалгал ба ЭЗЭНийг сонсох)нь үүнээс хамаардаг: Зохиогчоор хэрхэн заалгахыг сурах. Сүнс бол амь өгдөг.

ЭЗЭНий номноос олоод уншигтун. Тэдгээрийн нэг нь ч алга болохгүй, нэг нь ч ижлээ алдахгүй. Учир нь Түүний ам айлдаж, Түүний Сүнс тэднийг цуглуулсан юм. (Исаиа 34:16)

Би бол тэнгэрээс бууж ирсэн амьд талх байна. Хэрэв хэн нэгэн энэ талхнаас идвэл, тэр мөнхөд амьдарна. Ертөнцийн амийн төлөө Миний өгөх талх бол Миний махан бие юм гэж айлдлаа. 52 Тэгтэл иудейчүүд хоорондоо —Энэ хүн Өөрийнхөө махан биеийг бидэнд идүүлэхээр яаж өгч чадах юм бэ? гээд л маргалдаж эхлэв. 53 Есүс тэдэнд —Үнэнээр,

үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэхгүй, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй. (Иохан 6:51 – 53)

Харин Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун Сүнс та нарт бүх зүйлийг заах бөгөөд Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно. (Иохан 14:26)

Эхнээсээ сонссон зүйл чинь та нарын дотор байг. Хэрэв эхнээсээ сонссон зүйл чинь та нарын дотор байвал, та нар мөн Хүү болоод Эцэгийн дотор байх болно. 25 Энэ бол Тэр Өөрөө бидэнд амласан амлалт болох мөнх амь юм. 26 Та нарыг мэхлэхийг оролдож буй хүмүүсийн талаар эдгээрийг би та нарт бичсэн. 27 Та нарын Түүнээс авсан тосолгоо нь та нарын дотор байдаг бөгөөд өөрсдөд чинь заах хэн нэгэн та нарт хэрэггүй. Харин Түүний тосолгоо нь та нарт бүхнийг заадаг бөгөөд тэрхүү тосолгоо нь худал биш, үнэн. Та нарт заасан ёсоор та нар Түүний дотор байгтун.(1 Иохан 2:24 – 27)